



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ

МОНГОЛ УЛСАД ИРСЭН ОХУ-ЫН ЖУУЛЧДАД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ДЭМЖЛЭГ ТОДРУУЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Судалгааны институт
Улаанбаатар хот, 2022

АГУУЛГА

ГОЛ ҮР ДҮН	2
Нэг. Нөхцөл байдал.....	3
Хоёр. Дэмжлэг.....	8
Гурав. Судалгаанд оролцогчдын мэдээлэл	10

ГОЛ ҮР ДҮН

Энэхүү судалгаагаар МҮХАҮТ-аас Монгол улсад ирсэн жуулчдын нөхцөл байдал, Монгол улсад оруулж буй эдийн засгийн хувь нэмрийг тодорхойлон тооцох, цаашид манай улсад жуулчлахад шаардагдах дэмжлэгийг тодруулах зорилгоор цуврал судалгааг явуулж байна. Эхний цуврал судалгааг 2022 оны 10 сарын 10-25 өдрүүдэд цахим болон ярилцлагын хэлбэрээр, Монгол улсад ирсэн ОХУ-ын нийт 426 жуулчдыг хамруулан судалгааг авч үр дүнг нэгтгэсэн болно.


- Судалгаанд оролцогчдын 28.8 хувь нь аялал жуулчлалаар, 21.2 хувь нь Орос-Украины мөргөлдөөнд оролцохоос татгалзан дүрвэж ирсэн, 18.3 хувь нь ажил хийх, 12 хувь нь суралцах зорилгоор ирсэн байна. Эдгээр иргэдийн 34.8 хувь нь Англи хэлээр ярьдаг, ойлгодог, 42.1 хувь нь Монгол хэлийг ямар нэг хэмжээнд ярьж ойлгодог бол 24 хувь нь Монгол хэл мэдэхгүй байна.
- Бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх зорилгоор ирсэн иргэдийн 75 хувь нь худалдааны салбарт, 12.5 хувь нь мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарт ажиллах сонирхолтой байгаа ба 43.8 хувь нь 10 мянган ам.доллар хүртэлх дүнгээр, 31.3 хувь нь 11-100 мянган ам.долларын дүнгээр, 25 хувь нь 100 мянган ам.доллороос дээш дүнгээр хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байна.
- Судалгаанд оролцсон иргэдийн 97.9 хувь нь Улаанбаатар хотод байрлаж байгаа ба 40.2 хувь нь түрээсийн байранд, 39.8 хувь нь зочид буудалд, 15.5 хувь нь найз нөхөд, гэр бүлийнхээ гэрт амьдарч байна гэжээ.
- ОХУ-ын иргэд Монгол улсад байх хугацаанд нэг өдөрт дунджаар 161.6 мянган төгрөгийн, медиан утгаар 106 мянган төгрөгийн зардал гаргаж байна. Зардлын нэр төрлөөр ангилан авч үзвэл нэг өдөрт хамгийн их дундаж зардлыг байрлаж буй байрны түрээс болон зочид буудлын төлбөрт дунджаар 55.8 мянган төгрөг, хоолны зардалд дунджаар 39 мянган төгрөг, тээвэрт 12 орчим мянган төгрөгийг зарцуулж байна.
- Цаашид Монгол улсад хэр удаан хугацаанд байх төлөвлөгөөтэй байгааг тодруулахад 28.3 хувь нь нэг сараас дээш хугацаанд, 28.3 хувь нь Монгол улсад байнга оршин суух төлөвлөгөөтэй байгаа бол 34 хувь нь тодорхой хэлж мэдэхгүй гэжээ. Иргэдийн 82.6 хувь нь визээ сунгуулах хүсэлтэй байна.
- Ажиллах нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд судалгаанд оролцсон иргэдийн 90 орчим хувь нь ажиллах сонирхолтой байгаа ба мэдээллийн технологи (программ хангамжийн чиглэлээр), худалдаа үйлчилгээ, барилга, боловсролын салбарт илүү олон хүн ажиллах боломжтой бөгөөд судалгаанд оролцогчдын 17 хувь нь инженер, 9.3 хувь нь мэдээллийн технологи, программ хангамжийн инженер, 8.3 хувь нь багш, 5 орчим хувь нь эдийн засагч хуульч, 4 хувь нь эмч мэргэжилтэй байна.
- Гадаадын иргэн ажиллуулахад компаниуд өндөр татвар төлдөг учир ажил олж хийх орлого олох, орон сууц түрээсийн төлбөр өндөр ба найдвартай түрээслэх байр олох, оршин суух зөвшөөрөл авах, виз сунгах зэрэг нь Монгол улсад байрлах хугацаанд тулгарч буй хамгийн гол хүндрэлүүд байна гэжээ. Түүнчлэн Монгол улсад банкны данс нээлгэн карт авах, гүйлгээ хийхэд бэрхшээлтэй байна гэсэн байна.

Нэг. Нөхцөл байдал

Судалгаанд оролцсон гадаад иргэдээс энэхүү судалгаанд оролцох хүсэлтэй байгаа эсэхийг тодруулж, судалгаанд оролцох хүсэлтэй байгаа иргэдийн судалгааны үр дүнг нэгтгэсэн болно.

Судалгаанд оролцогчдоос Монгол улсад ирсэн зорилгыг тодруулахад 28.8 хувь нь аялал жуулчлал хийх, 18.3 хувь нь ажил хийх, 12 хувь нь сурах, 7.4 хувь нь найз нөхөд хамаатан садандаа зочлох, 4.8 нь бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх зорилготой ирсэн гэсэн бол 32.1 хувь нь бусад зорилгоор ирсэн гэжээ. (Зураг 1).


Зураг 1. Монгол улсад ирсэн аяллын зорилго



Монгол улсад ирсэн аяллын зорилго бусад гэж хариулсан иргэдийн хариултыг нарийвчлан харвал 21.2 хувь нь Орос-Украины мөргөлдөөнд оролцохоос татгалзан дүрвэж ирсэн, 3.1 хувь нь өөр улс руу дамжин өнгөрч байгаа гэсэн байна.

Монгол улсад бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх зорилгоор ирсэн иргэдийн 75 хувь нь худалдааны салбарт, 12.5 хувь нь мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарт, 12 хувь нь бусад салбарт бизнес эрхлэх сонирхолтой байна гэжээ. Мөн эдгээр иргэдээс хөрөнгө оруулалт хийхээ төлөвлөж буй дүнг тодруулахад 43.8 хувь нь 10 мянган ам.доллар хүртэлх дүнгээр, 31.3 хувь нь 11-100 мянган ам.долларын дүнгээр хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгаа бол 25 хувь нь 100 мянган ам.доллаароос дээш дүнгээр хөрөнгө оруулалт хийнэ гэж төлөвлөж байна. (Зураг 2).

Зураг 2. Монгол улсад хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн хэмжээ



Монгол улсад суралцахаар ирсэн иргэдийн хувьд 45.7 хувь нь Монгол хэлний сургалтад суралцах, 26.1 хувь нь дээд боловсрол эзэмших, 6.5 хувь нь мэргэжлийн боловсрол сургалтын төвд суралцах зорилготой байгаа гэжээ.


Монгол улсад ирсэн ОХУ-ын иргэдийн 82.6 хувь нь визээ сунгуулах хүсэлтэй байгаа бол 11.2 хувь нь одоогоор шийдээгүй, 5.2 хувь нь өөр улс руу явахаар төлөвлөж байна. Түүнчлэн визээ сунгуулах хүсэлтэй иргэдийн 54 хувь нь виз сунгах хүсэлтээ гаргаагүй байгаа бол 46 хувь нь хүсэлтээ гаргасан байна гэжээ. (Зураг 3)

Зураг 3. Монгол улсад байх хугацаандаа үргэлжлүүлэн визээ сунгах хүсэлтэй байгаа эсэх




Судалгаанд оролцсон иргэдийн гадаад хэлний мэдлэгийг тодруулахад 34.8 хувь нь Англи хэлээр ярьдаг, ойлгодог, 42.1 хувь нь Монгол хэлийг ямар нэг хэмжээнд мэддэг бол 24 хувь нь Монгол хэл мэдэхгүй гэжээ. (Зураг 4)

Зураг 4. Гадаад хэлний мэдлэг




Монгол улсад ирээд ямар хугацаанд байгаа тухайд 21.9 хувь нь 10 хоног дотор, 41 хувь нь 11-14 хоног, 36.9 хувь нь 14 хоногоос дээш хугацаатай байна гэжээ. (Зураг 5)

Зураг 5. Монгол улсад байгаа хугацаа



Судалгаанд оролцсон иргэдийн 97.9 хувь нь Улаанбаатар хотод, 1 хувь нь Эрдэнэт, Дархан хотуудад, 1.2 хувь нь бусад аймгуудад байрлаж байна. Түүнчлэн ямар орон байрт амьдарч байгааг тодруулахад 40.2 хувь нь түрээсийн байранд, 39.8 хувь нь зочид буудалд, 15.5 хувь нь найз нөхөд, гэр бүлийнхээ гэрт амьдарч байна гэжээ. (Зураг 6)

Зураг 6. Монгол улсад хаана байрлаж байна вэ?



ОХУ-ын иргэд Монгол улсад байх хугацаанд ямар хэмжээний зардал гаргаж байгаа тухайд тооцох зорилгоор зардлын нэр төрлөөр нэг өдөрт гаргаж буй дундаж зардлыг тодрууллаа. Судалгаанд оролцсон нэг жуулчин дунджаар 161.6 мянган төгрөгийн зардлыг өдөрт гаргаж байна. Өдөрт зарцуулж буй нийт зардлын медиан утга нь 106.1 мянган төгрөг байна.


Зардлын нэр төрлөөр ангилан авч үзвэл хамгийн их дундаж зардлыг байрлаж буй байрны түрээс болон зочид буудлын төлбөрт зарцуулж байгаа ба нэг өдөрт дунджаар 55.8 мянган төгрөг зарцуулж байна. харин үүний дараагаар өдөрт дунджаар 39 мянган төгрөгийг хоолны зардалд зарцуулж байгаа бол 12 орчим мянган төгрөгийг тээврийн зардалд зарцуулж байна гэжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Нэг өдөрт зарцуулж буй зардлын дүн, нэр төрлөөр

Зардлын нэр төрөл	ДУНДАЖ		МЕДИАН	
	Рубль	Төгрөг	Рубль	Төгрөг
Байрны түрээс /зочид буудлын өдрийн төлбөр/	1,005	55,790	800	44,392
Хоол	700	38,842	500	27,745
Тээвэр	215.4	11,953	100	5,549
Хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авах зардал	569	31,555	5,549	18,478
Бусад үйлчилгээ	423	23,475	180	9,988
Нийт зардал /нэг хүн өдөрт, дунджаар/	2,912	161,614	7,129	106,152


Цаашид Монгол улсад хэр удаан хугацаанд байх төлөвлөгөөтэй байгааг тодруулахад 9.3 хувь нь нэг сар хүртэлх хугацаанд, 28.3 хувь нь нэг сараас дээш хугацаанд оршин суух төлөвлөж байгаа бол 24.3 хувь нь Монгол улсад байнга оршин суух төлөвлөгөөтэй байна. Харин 34 хувь нь тодорхой хэлж мэдэхгүй байна гэжээ. (Зураг 7)

Зураг 7. Монгол улсад байрлахаар төлөвлөж буй хугацаа




Ажиллах нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд Монгол улсад ажиллах сонирхолтой байгаа эсэхийг тодруулахад 90 орчим хувь нь ажиллана гэсэн бол 10 хувь нь ажиллах сонирхолгүй байна гэжээ. Ажиллах сонирхолтой байгаа судалгаанд оролцогчдоос ямар салбарт ажиллах, ямар мэргэжил эзэмшсэн тухайд тодруулахад 17.6 хувь нь мэдээллийн технологи (программ хангамжийн чиглэлээр), 13.3 хувь нь үйлчилгээ, 10.5 хувь нь барилга, 7.6 хувь нь худалдаа, 7.1 хувь нь боловсролын салбарт ажиллах боломжтой байна гэжээ. (Зураг 8)

Зураг 8. Ажиллах сонирхолтой салбар



Судалгаанд оролцсон иргэдээс ямар мэргэжилтэй тухайд тодруулахад 17 орчим хувь нь инженер, 9.3 хувь нь мэдээллийн технологи, программ хангамжийн инженер, 8.3 хувь нь багш, 5 орчим хувь нь эдийн засагч болон хуульч, 4 хувь нь эмч мэргэжилтэй гэжээ. (Зураг 9)


Зураг 9. Ямар мэргэжилтэй вэ?



Хоёр. Дэмжлэг


Судалгаанд оролцогчдоос Монгол улсад байх хугацаандаа шаардагдах дэмжлэгээ хэнээс авч байгаа тухайд тодруулахад 70 орчим хувь нь Монгол улсад амьдардаг найз нөхөд, танилуудаас авч байна гэжээ. Шаардлагатай мэдээллээ хаанаас авч байгаа тухайд 83 хувь нь нийгмийн сүлжээгээр, 13 хувь нь танил найз нөхөд, 4 хувь нь веб хуудсаар авч байна гэжээ. (Зураг 10)

Зураг 10. Хэрэгцээтэй мэдээлэл авч буй эх үүсвэр



Цаашид Монгол улсад байрлахад ямар төрлийн мэдээлэл хэрэгцээтэй байгааг тодруулахад 21 хувь нь хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны талаар мэдээлэл, 25 хувь нь оршин суух зөвшөөрөл, визний тухайд мэдээлэл, 13 хувь нь байр орон сууц худалдан авах, түрээслэх тухай мэдээлэл, 9 хувь нь Монгол хэл суралцахтай холбогдох мэдээлэл, 7 хувь нь хууль дүрэм журмын талаар нэгдсэн мэдээлэл авах, мөн 7 орчим хувь нь нийтийн тээвэр болон хотын хаягжилтын мэдээллийг ойлгомжтой хүртээмжтэй болгох шаардлагатай байна гэжээ. (Зураг 11)

Зураг 11. Монголд байрлах хугацаанд шаардагдах мэдээлэл




Судалгаанд оролцсон ОХУ-ын иргэдээс Монгол улсад байрлах хугацаанд тулгарч буй хамгийн гол бэрхшээл юу байгаа тухайд тодруулахад 30.5 хувь нь гадаадын иргэн ажиллуулахад компаниуд өндөр татвар төлдөг учир ажил олж хийх орлого олоход хүндрэлтэй байна гэсэн бол 16.2 хувь нь орон сууц түрээсийн төлбөр өндөр ба найдвартай түрээслэх байр олох нь бэрхшээл үүсгэж байна гэжээ. Мөн 13.8 хувь нь хэлний мэдлэг дутмаг байгаа нь бэрхшээл болж байна гэсэн бол 20.5 хувь нь оршин суух зөвшөөрөл авах, виз сунгах нь хамгийн гол тулгамдсан асуудал болоод байна гэжээ. Түүнчлэн оршин суух зөвшөөрөл авч чадаагүй байгаа учир Монголд банкны данс нээлгэх, карт авах үйлчилгээг авч чадахгүй байгаа ба гүйлгээ хийхэд хүндрэлтэй байна гэсэн байна. (Зураг 12)

Зураг 12. Тулгарч буй гол хүндрэл



Цаашид монгол улсад байрлахад ямар дэмжлэг хэрэгтэй байгаа тухайд 28.3 хувь нь ажил хийж орлого олоход дэмжих, 16.7 хувь нь хямд үнэтэй түрээсийн орон байр олоход дэмжих, 20 хувь нь оршин суух зөвшөөрөл авах визний хугацааг сунгахад дэмжлэг хэрэгтэй байна гэжээ. (Зураг 13)


Зураг 13. Хэргэцээтэй дэмжлэгүүд



Гурав. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгааг 2022 оны 10 сарын 10-25 өдрүүдэд цахим болон ярилцлагын хэлбэрээр, Монгол улсад ирсэн ОХУ-ын нийт 426 жуулчдыг хамруулан судалгаа авч үр дүнг нэгтгэсэн болно.

Судалгаанд оролцсон иргэдийн 83 хувь нь эрэгтэй, 17 хувь нь эмэгтэй ба оролцогчдын 65 хувь нь буриад, 25 хувь нь орос, 10 хувь нь бусад үндэс угсааны иргэд байна. Насны бүлгээр ангилан авч үзвэл 68.1 хувь нь 34 хүртэлх насны иргэд, 19 хувь нь 35-40 насны иргэд, 12.4 хувь нь 40-өөс дээш насны иргэд байна.





МҮХАҮТ-ын Судалгааны институт

Монгол Улс, Улаанбаатар хот 17011,
Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма
Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр

Утас: +976-77277070

Факс: +976-11-324620

 research@mongolchamber.mn